



VII-IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 8




Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого өмнөх улирлаас 14 тохиолдлоор буурлаа

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2021 оны 3 дугаар улиралд 56 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 18 (24.3%), өмнөх улирлаас 14 (20.0%) -өөр буурсан байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 18 (32.1%) тохиолдол унах бүдрэх, хальтирснаас үүссэн бол эд зүйлд хавчуулагдсан 8 (14.3%), унаж байгаа эд зүйлд цохигдсон 6 (10.7%), цахилгаан гүйдэлд цохиулсан 5 (8.9%), гадны халдлагад өртсөн 4 (7.1%), халсан, түлэгдсэн, хөлдсөн 2 (3.6%), эд зүйл дээр гишгэсэн суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдсон 1 (1.8%), хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөнд өртсөн 1 (1.8%), живсэн 1 (1.8%), бусад 10 (17.9%) тохиолдол бүртгэгдсэн байна.

Нийт осолдогчдын 21 (37.5%) нь хөнгөн хэлбэрээр, 24 (42.9%) нь хүнд хэлбэрээр осолдож, 11 (19.6%) хүн нас барсан байна.

ЗУРАГ 1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, бүсээр, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар



Нийт осолдогчдын 15 (26.8%) нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 2021 оны 3 дугаар улиралд Баруун бүсэд 5 (8.9%), Хангайн бүсэд 2 (3.6%), Төвийн бүсэд 13 (23.2%), Зүүн бүсэд 3 (5.4%), Улаанбаатар хотод 32 (57.1%), бусад буюу Улаанбаатар төмөр замд 1 (1.8%) тохиолдол бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 2. ОСОЛДОГЧИД, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар




Осолдогчдыг насны бүлгээр авч үзэхэд 14 хүртэлх насны 1 (1.8%), 18-24 насны 13 (23.2%), 25-34 насны 17 (30.4%), 35-44 насны 9 (16.1%), 45-59 насны 13 (23.2%), 60, түүнээс дээш насны 3 (5.3%) байна.

ХҮСНЭГТ 1. ОСОЛДОГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар

Салбар	2019 VII-IX	2020 VII-IX	2021 VII-IX
Дүн	75	74	56
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	-	1
Уул уурхай, олборлолт	20	5	12
Боловсруулах үйлдвэрлэл	5	4	7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4	2	1
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1	1	1
Барилга	11	19	2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	3	1	2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	7	11	4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4	1	3
Мэдээлэл, холбоо	2	2	-
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	-	3	1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2	-	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2	7	5
Боловсрол	2	3	1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3	3	6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	8	12	9

Нийт осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр нь авч үзвэл, энгийн ажил мэргэжилтэй хүн 12 (21.4%), үйлдвэрлэл, барилга, гар урлалтай, холбоотой ажил, үйлчилгээний ажилтан 10 (17.9%), техникч болон туслах, дэд мэргэжилтэн 10 (17.9%), суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч 8 (14.3%), зэвсэгт хүчний ажилтан, мэргэжилтэн 5 (8.9%), худалдаа үйлчилгээний ажилтан 5 (8.9%), контор, үйлчилгээний ажилтан 3 (5.4%), менежер 2 (3.5%), мэргэжилтэн 1 (1.8%) байна.

ЗУРАГ 3. ОСОЛДОГЧИД, ажил мэргэжлийн ангилалаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны 3 улирлын байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэлийн осол:

Хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

Хурц хордлого:

Цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

Осолдогч:

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг ойлгоно.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан:

Иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.

Бүлэг осол, хурц хордлого:

Нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно.



Эх үүсвэр:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Ангилал, код:

ISCO-08 - ажил, мэргэжлийн ангилал, ISIC-4 - эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ICD-10- өвчний олон улсын ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2022 оны 1 дүгээр сарын 14

Нийгмийн статистикийн газрын
Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн
статистикч Н. Алтантүлхүүр
Утас : (976-51)-265543

Нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805

